



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/865

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 2.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Буянт сумын Цагаанбургас багийн нутаг Цагаан, Мандал, Хэрс, Завсар зэрэг арлуудад 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн хүчтэй шуурганы улмаас Хар-Ус нуурын усанд үхсэн малын сэг зэмийг гаргаж, стандарт, норм дүрмийн дагуу устгалын ажил зохион байгуулсан Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газрын албан хаагчдын томилолт, шатахууны зардалд 3 200 000 төгрөг, Булган сумын Байтаг багийн Цагаан толгой гэх газар хууль бусаар алт олборлож байгаа иргэдийн аюулгүй байдлыг хангаж 2019 оны 11 дүгээр сарын 13-наас 27-ны өдрүүдэд хамгаалтанд гарсан Цагдаагийн газрын алба хаагчдын томилолт, шатахууны зардалд 7 591 000 төгрөг, 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Ховд Дулааны Станц төрийн өмчит үйлдвэрийн газрын конверын хэсэгт гал түймэр гарч тус дулааны станцаас дулаанаар хангагддаг аж ахуйн нэгж байгууллага, айл өрхийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн алба хаагчдын томилолт, хувцас, хүнсний зардалд 5 000 000 төгрөг, Шувууны хачигны тандалт судалгаа хийсэн алба хаагчдын шатахуун, хувцас хэрэгслийн зардал 141 500 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 15 932 500 төгрөг /Арван таван сая есөн зуун гучин хоёр мянга таван зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гамшгийн зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

Zax A/865 Ch
02 04270

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д, үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ